# ОРХОН АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 24 өдөр Дугаар А/102 Баян-Өндөр сум

Орон тооны бус шинжээч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/383 тушаалын 1.11 заалт Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам батлах тухай" А/402 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын орон тооны бус шинжээчийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Шинээр зөвшөөрөл хүссэн байгууллагын төсөл болон ажлын байрны үнэлгээний дүгнэлтийг гаргаж комиссын хуралд танилцуулж ажиллахыг шинжээч нарт үүрэг болгосугай.

3. Ажлын байранд шинжээчдийн багийн үнэлгээ хийх ажлын удирдамжийг батлуулан, шинжээчидтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, үнэлгээ хийх болон ёс зүйн сургалтад хамруулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг ажлын албад даалгасугай.

3. Шинжээч нарыг 3 жилийн хугацаатай томилж, ажлын үнэлэх олгохыг комиссын нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны ..... сарын ..... өдрийн
..........тоот тушаалын хавсралт

ОРОН ТООНЫ БУС ШИНЖЭЭЧИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Д.Одонтуяа-Ачит эмнэлгийн их эмч
2. Л.Баттогтох –ЭҮТӨҮГ-ын Эрдэнэт Медикал төрөлжсөн төв эмнэлгийн клиник эм зүйч